



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 613

Улаанбаатар хот

**Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн  
мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэх аргачлал”-ын 3.6, 4.1, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2022 оны биелэлтийн дүнгээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай дүгнэлт, зөвлөмжийг нэгдүгээр хавсралтаар баталж төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлж, хэрэгжүүлж ажиллахыг даалгасугай.

2.Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2022 оны биелэлтийн дүнгээр илэрсэн хоёрдугаар хавсралтад заасан зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч ажиллахыг төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт даалгасугай.

3.Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний үүргээ хамгийн сайн биелүүлсэн гуравдугаар хавсралтад заасан төрийн өмчит хуулийн этгээд, дөрөвдүгээр хавсралтад заасан ажилтан албан хаагчдыг шагнаж урамшуулахыг зөвшөөрсүгэй.

4.Төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтгүй байгаа тавдугаар хавсралтад заасан барилга байгууламжид магадлах ажиллагаа хийж, худалдах, шилжүүлэх асуудлаар санал боловсруулан 2024 оны 2 дугаар улиралд багтаан танилцуулахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

5.Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл), Захиргаа, удирдлагын хэлтэс (Н.Ганболд), Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ), Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа), Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Дэлгэрмаа)-т тус тус даалгасугай:

5.1.Төрийн болон орон нутгийн өмчийн 2022 оны улсын үзлэг, тооллогын дүнгээр газар эзэмших ашиглах эрхийн баталгаажилт, үнэлгээ, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн бүртгэл, ашиглалтад илэрсэн зөрчил дутагдлыг арилгаагүй төрийн өмчит хуулийн этгээдэд хугацаатай Албан даалгавар, албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавих;

5.2.Бүртгэлгүй, ашиглалтгүй, дутаасан, маргаантай үндсэн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөө гарган ажиллаж, шаардлагатай тохиолдолд хууль

хяналтын байгууллагад хандах, үл хөдлөх хөрөнгийн хувьд газар дээр нь магадлах ажиллагаа явуулж дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах.

6.Төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхийг даалгасугай;

6.1.Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн доорх газрын эзэмших, ашиглах эрхийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу баталгаажуулах, үнэлэх, бүртгэлд тусгах, Засгийн газрын 2013 оны 38 дугаар тогтоолын 6 дугаар заалт, 2020 оны 10 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

6.2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн зөрчлийг арилгах, цахимд систем ([www.egazar.gov.mn](http://www.egazar.gov.mn))-д бүртгүүлээгүй буюу Э-дугааргүй газрыг тухайн аймаг, дүүрэг, сумын газрын албанд хандан холбогдох журмын дагуу бүртгүүлэх, гэрчилгээг шинэчилж QR кодтой болгох ажлыг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан хэрэгжүүлэх;

6.3.Төрийн болон орон нутгийн өмчийн 2022 оны улсын үзлэг, тооллогын дүнгээр Төрийн мэдээлэл солилцооны систем “Хур”, “Авто тээврийн үндэсний төв”-ийн улсын бүртгэлтэй зөрүүтэй байгаа нь илэрсэн тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг тулган баталгаажуулж, зөрчил дутагдлыг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

6.4.Хуулийн этгээдийн ерөнхий мэдээлэл нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын “open data”-тай мэдээлэлтэй зөрсөн, холбогдох өөрчлөлтийг хийлгээгүй зөрчлийг арилгаж, байгууллагынхаа мэдээллийг шинэчлэх арга хэмжээг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан авч хэрэгжүүлэх;

6.5.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан төрийн өмчит хуулийн этгээдийн “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөн ажиллаж, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

6.6.Хөрөнгийн зохицуулалт, ашиглалттай холбоотой эрх бүхий байгууллагаас гарсан тогтоол, шийдвэрийг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг тайлагнаж хэвшүүлэх;

6.7.Хөрөнгө бүртгээгүй, дутаасан холбогдох ажилтан, албан хаагчдад хариуцлага тооцох, бүртгэх, хохирлыг тогтоох, нөхөн төлүүлэх арга хэмжээ авах;

6.8.Ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг судлан шилжүүлэх, худалдах, засаж сэлбэх асуудлыг яаралтай шийдвэрлүүлэх, маргаантай хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөө гарган ажиллаж, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад хандах, үл хөдлөх хөрөнгийн хувьд газар дээр нь холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан магадлах ажиллагаа явуулж дүгнэлт гаргах ажлыг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулах;

6.9.Энэ шийдвэрийг хэрэгжүүлж биелэлтийг 2024 оны 4 дүгээр сарын 01-ний дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

7.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ  
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

*D. Narangerel* Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 11 дүгээр сарын 31-ны өдрийн  
613 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ 2022 ОНЫ  
БИЕЛЭЛТИЙН ДҮНГЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АНГА  
ХЭМЖЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 тогтоол, тус тогтоолоор баталсан аргачлалын дагуу төрийн өмчийг эзэмшүүлэх 2022 оны гэрээний биелэлтийг дүгнэсэн бөгөөд бүх байгууллагад хүрч ажиллах цаг хугацаа, хүн хүчний боломжгүйгээс зарим байгууллагыг цахимаар дүгнэсэн болно.

Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2022 оны биелэлтийн дүнгийн товчоо

<b>Авсан онооны дундаж дүн (хувь) үндсэн шалгуур үзүүлэлтээр</b>						
<b>ТӨЭГ дүгнэгдсэн хуулийн этгээдийн тоо</b>	<b>Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт- ын байдал (30/25)</b>	<b>Хөрөнгийн хөдлөл еөрчлөлт, бүртгэл,мэдээ тайлан, шийдвэрийн хэрэгжилт, тайлагналын байдал (40/40)</b>	<b>ТБОНӨ-ийн цахим мэдээллийн системийн байдал (10/10)</b>	<b>Газар эзэмших, ашиглах эрхийн байдал (10/10)</b>	<b>Гэрээ дүгнүүлэх бэлтгэл хангасан байдал (10/10)</b>	<b>Нийт оноо (хувь)</b>
<b>1021</b>	<b>23.5</b>	<b>38.13</b>	<b>9.9</b>	<b>8.5</b>	<b>9.5</b>	<b>93.05</b>

Дээрх 5 үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан үзүүлэлтийг хангасан байдал нь 93.05 хувьтай байна.

Төрийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд бүртгэлээр хяналт тавих чиг үүргийн хүрээнд төрийн өмчит хуулийн этгээдтэй байгуулдаг Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний үр дүнд өмч эзэмшигч байгууллагуудын өмчид хандах хандлага, өмч эзэмшилт, хамгаалалт сайжирч, хөрөнгийн үр ашиг дээшилж, зөрчил дутагдал жилээс жилд буурсаар байна.

Гэсэн хэдий ч гэрээний дүнгээр байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн журмын хэрэгжилт, үйл ажиллагаа нь хангалтгүй, эд хөрөнгийн зохицуулалтын асуудлаарх тогтоол шийдвэрийн биелэлтийг заасан хугацаанд тайлагнаагүй, хөрөнгийн дүн зөрүүтэй, хөрөнгийн нэршил оновчтой бус, гадаад хэлээр бичигдсэн, хөрөнгийг дансны ангилалын дагуу бүртгээгүй гэх зэрэг зөрчил дутагдал давтагдан гарсан байна.

## **1.ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ДУТАГДЛЫН ТАЛААРХ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

1.1.Байгууллагын Өмч хамгаалах Байнгын зөвлөл (БӨХБЗ) нь журмын дагуу тухайн жилд хийсэн ажлын тайланг бэлтгэж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг цаг хугацаандаа тайлагнах, хөрөнгийн чанар байдал, ашиглалт, хадгалалтын байдал, үр ашгийг дээшлүүлэхэд хяналт тавих үүргээ хангалтгүй биелүүлж байгаа тул үйл ажиллагаагаа идэвхжүүлэх шаардлагатай байна.

1.2.Элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоолгох ажлыг цаг хугацаандаа хийхгүй байгааг анхаарч ажиллах нь зүйтэй.

1.3.Барилгын хувийн хэрэг болон тээврийн хэрэгслийн паспортын хөтлөлт, баяжуулалтыг тухай бүр хийж, гэрчилгээ, холбогдох баримтыг хуулбарлан хавсаргаж хэвших хэрэгтэй байна.

1.4.Үндсэн хөрөнгийн дансны ангилалыг буруу тодорхойлсон, хөрөнгийн нэршил оновчгүй, тодорхойгүй, гадаад хэлээр бүртгэлд тусгасан байдлыг монгол хэлээр зөв томъёолох, залруулга хийж байх.

1.5.Тээврийн хэрэгслийн үзлэг шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал. Үүнд:

- Тээврийн хэрэгслийг акталж, худалдаж данснаас хассан тухай бүр тээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулдаггүй, гэрчилгээ эзэмшигч байгууллагын нэр дээр бүртгэлгүй хувь хүний дээр байдаг зөрчил байсаар байна.
- Олон жил ашиглаж элэгдэж дууссан, ашиглалтын шаардлага хангахгүй, болон засварын зардалгүйн улмаас засаж сэлбэж чадахгүй зогссон хөдөлгөөнд оролцоогүй нэлээд тээврийн хэрэгслүүд байна. Тэдгээрийн татвар, хураамжийг төлөөгүй байгаа нь дараа нь уг тээврийн хэрэгслийн бүртгэлээс хасуулах үед төлбөр хураамжийг нөхөн төлөх асуудал тулгардаг.

1.6.Иймд Авто тээврийн үндэсний төвөөс өөрийн байгууллагын нэр дээр бүртгэлтэй байгаа тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээг авч Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын бүртгэлийн мэдээтэй тулган баталгаажуулж, 2024 оны 1 дүгээр улиралд багтаан илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, албан татварын тооцоог хийж, шилжилт хөдөлгөөнийг тухай бүр тусгуулж байх;

1.7.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 323 дугаар тогтоолоор баталсан төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн болон Захиргааны статистикийн маягтуудыг зааврын дагуу байнга хөтөлж, тайлагнах хугацаанд нь ирүүлж байх;

1.8.Эд хөрөнгийн зохицуулалтын асуудлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж хэвших хэрэгтэй байна.

1.9.Хөрөнгө олж авах, данснаас хасах саналаа эрх бүхий дээд байгууллагадаа уламжлан дэмжсэн санал авч, дээрх журамд заасан баримтын бүрдлийг бүрэн хангаж албан бичигт хавсарган ирүүлж байх нь зүйтэй юм.

1.10.Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, биелэлтийг тогтоолд заасан хугацаанд ирүүлж тайлагнаж хэвших хэрэгтэй.

1.11.Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн доорх газрын эзэмших, ашиглах эрхийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу баталгаажуулах, үнэлэх, бүртгэлд тусгах, Засгийн газрын 2013 оны 38 дугаар тогтоолын 6 дугаар заалт, 2020 оны 10 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

1.12.Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэхдээ Засгийн газрын 2001 оны 134, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолын мөрдлөг болгож түрээслэгчийг сонгон шалгаруулж байх, хөрөнгө түрээслэх зөвшөөрөл авч байх, гэрээг баталгаажуулах, түрээсийн төлбөрийг цаг хугацаанд нь тооцоо нийлж Улсын төсөвт төвлөрүүлж байх;

1.13.Өмч хамгаалах Байнгын зөвлөл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 дугаар тогтоолын дагуу жил бүр Төрийн өмч эзэмшүүлэх гэрээг дүгнүүлэх бэлтгэлийг хангаж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан журмын хүрээнд жилийн тайлангаа бэлтгэж хэвших нь зүйтэй байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн  
613... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭГИЙН 2022 ОНЫ БИЛЭЛТИЙН  
ДҮНГЭЭР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ДУТАГДУУЛСАН ЖАГСААЛТ**

Д/д	Зөрчил гаргасан байгууллагын нэрс	Илэрсэн зөрчил	Тайлбар
<b>1.Төрийн өмчийн 2022 оны улсын үзлэг тооллогоор илэрсэн зөрчил</b>			
1	Төрийн өмчийн 2022 оны улсын үзлэг тооллогоор дутагдуулсан бөгөөд шийдвэрлэгдээгүй байгаа хөрөнгө (жагсаалтаар)	дутагдуулсан	Нийт 12 төсвийн ерөнхийлөн захирагчийн дутагдуулсан 95 ширхэг 2,235.6 сая төгрөгийн хөрөнгөнөөс 64 ширхэг 2,050.0 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлээгүй байна.
2	Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогоор маргаантай байгаа хөрөнгө (жагсаалтаар)	маргаантай	Нийт 14 төсвийн ерөнхийлөн захирагчийн маргаантай 4009 ширхэг 13,491.7 сая төгрөгийн хөрөнгөнөөс 4001 ширхэг 12,888.8 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлээгүй байна.
<b>2.Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээгээр илэрсэн зөрчил</b>			
3	Өмнөговь аймаг Татварын хэлтэс	Төрийн мэдлийн газар дээр орон сууц барьсан	ТӨБЗГ-ын 2018 оны 09 сарын 19-ны өдрийн 388 дугаар тогтоолын 2.3 дахь заалтад " Үл хөдлөх хөрөнгийг акталж буулгах, газар (чөлөөлөгдөх талбай)-г албан ажлын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх;" гэж зааж өгсөн. Тус тогтоолд ямар нэгэн өөрчлөлт ороогүй байхад Аймгийн Татварын хэлтсийн эзэмшлийн газар дээр хувийн өмчийн "Зана констракшн" ХХКомпани 2022 оны намраас татварын хэлтсийн хуучин барилгыг нурааж, суурин дээр нь 9 давхар үйлчилгээтэй орон сууц бариж эхэлсэн байна. Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн А/1241 дугаар захирамжаар газар эзэмших эрхийг цуцлан тус компанийн нэр дээр шилжүүлсэн байна. Одоогоор барилгын ажил 100 % дуусч Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн у-2023/79 дугаар дүгнэлтээр ашиглалтад хүлээн авчээ. Энэ асуудлаар ТЕГ-т 2023 оны А-1/1239 дугаар албан бичиг хүргүүлсэн.

4	Сүхбаатар аймаг Хүнсхөдөө аж ахуйн газар	Хөрөнгө дутагдуулсан	Сүхбаатар аймагт ажиллах хугацаанд тус аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Түмэнцогт суманд барьж байгуулсан нийт 198,401,995.00 (нэг зуун ерэн найман сая дөрвөн зуун нэг мянга сөн куун ерэн таван) төгрөгийн үнэ бүхий сум дундын нядалгааны цехийн барилга, тоног төхөөрөмж алдаж үрэгдсэн зөрчлийг илрүүлсэн. АТГ 2023.06.22№А-1/1255 тоотор хандсан.
5	Мэргэжлийн хяналтын газар	1 өрөө орон сууцыг бүртгэлд тусгуулсан	Тус орон сууцийг бүртгэлд оруулаагүй бөгөөд МХЕГ татан буугдахад эзэнгүй орхигдсон байсаныг илрүүлэн ХХЕГ-ын 0108 дугаар ангид шилжүүлэн өгсөн. ТӨБЗГ-ын 2023,09,27№470 дугаар тогтоолоор шийдсэн.
6	Цэнгэг ус	Эзэмшил газраа гэрчилгээжүүлж, үнэлж бүртгэлд тусгаагүй	Бүртгэлд тусгаагүй өөрийн эзэмшлийн газраа
7	Биеийн тамир спортын хороо	Авто зогсоолын талбай хувь хүний нэр дээр	Тус байгууллага нийтийн эзэмшлийн авто зогсоолоо өөрийн бүртгэлдээ аваагүй хувь хүний нэр дээр байна. Өөрийн эзэмшил газар барилгын сууриар байна. 250м2 талбайгаа adidas дэлгүүрт түрээслэн сүүлийн 6 жилийн түрээсийн төлбөр аваагүй шүүхэд шилжүүлэн түрээсийн төлбөр бүрэн төлүүлэх шүүхийн шийдвэр гарсан.
8	Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн	2 ширхэг автомашин дутагдуулсан	УАЗ-31512 маркийн УБО 1426 улсын дугаартай, Хондай Сивик маркийн УБО 5369 улсын дугаартай 2 ширхэг автомашин балансад бүртгэлтэй боловч биетээр байхгүй дутагдуулсан.
9	Богд хаан уулын дархан цаазат уулын захиргаа	Төрийн мэдлийн газар дээр орон сууц барьсан	Хан-Уул дүүрэг дэх 0,7 га газар дээрээ орон сууц бариулсан.
10	Богд хаан уулын дархан цаазат уулын захиргаа	Зөвшөөрөлгүйгээр хөрөнгө шилжүүлсэн	79-68 УНК Поргон автомашиныг Төв аймгийн Байгаль орчны газарт зөвшөөрөлгүйгээр шилжүүлсэн.
11	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын Прокурорын газар	Газар бүртгэлжүүлсэн	Төрийн захиргааны зориулалтаар 2021 онд эзэмшүүлсэн 3557м2 газрыг үнэлэн данс бүртгэлд тусгуулсан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн  
613 дугаар тогтоолын үндсэндээгээр хэвсралт

**ТӨРИЙН ӨМЧИЙН ЭЗЭМШҮҮЛЭХ 2022 ОНЫ ГЭРЭЭНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ДҮНГЭЭР ШАГНАЖ УРАМШУУЛАХ ТӨРИЙН  
ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ**

д/д	Төрийн өмчит хуулийн этгээдийн нэр	Гэрээний биелэлтийн дүн (хувиар)
1	Авилгатай тэмцэх газар	99%
2	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	96%
3	Гаалийн ерөнхий газрын харьяа Улаанбаатар хотын гаалийн газар	96%
4	Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК	99%
5	Өвөрхангай аймаг дахь Политехник коллеж	96%
6	Санхүүгийн зохицуулах хороо	96%
7	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба	96%
8	Дундговь аймаг Хүнс, хөдөө аж ахуйн газар	97%
9	Дундговь аймаг дахь Прокурорын газар	96%
10	Дундговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	96%
11	Архивын ерөнхий газар	96%
12	Цагдаагийн ерөнхий газрын автобааз	96%
13	Дотоод хэргийн их сургууль	96%
14	Шинжлэх ухаан технологийн их сургууль	96%
15	Өвөрхангай аймаг дахь Татварын хэлтэс	96%
16	Төрийн тусгай хамгаалалтын газар	96%
17	Хил хамгаалах ерөнхий газар	96%
18	Гашуунсухайт дахь Гаалийн газар	96%

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 1-дүгээр сарын 3-ны өдрийн  
6.13 дугаар тогтоолын дөрвөдүгээр хэвсрэлт

**ТӨРИЙН ӨМЧИЙН 2022 ОНЫ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН  
ДҮНГЭЭР ШАГНАЖ УРАМШУУЛАХ АЛБАН ХААГЧДЫН ЖАГСААЛТ**

д/д	Төрийн өмчит хуулийн этгээдийн нэр	Албан тушаал	Нэр
1	Булган аймаг дахь Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв	Ерөнхий нягтлан бодогч	Т.Ариунбат
2	Цагдаагийн ерөнхий газрын санхүү, ар талын албаны санхүүгийн хэлтэс	Ахлах нягтлан бодогч	Д.Болормаа
3	Завхан аймаг дахь Тарвагатай нурууны БЦГХЗ	Нягтлан бодогч	М.Чимэдноров
4	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй хаалттай хорих анги	Нягтлан бодогч	С.Нэргүй
5	Эмгэг судлалын үндэсний төв	Нягтлан бодогч	М.Саранцэцэг
6	Монгол улсын боловсролын их сургууль	Нягтлан бодогч	В.Цэндсүрэн
7	Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа	Нягтлан бодогч	Ш.Туяа

Төрийн өмчийн бөдөлгөөр зохицуулагдсан газрын  
 2023 оны 4 дүгээр сарын 16 өдрийн  
 613... дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ АМАРАЛТЫН  
 БАЙГАА БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн байршил, (эзэмшигч байгууллага)	Шилжүүлэх хөрөнгө	Хөрөнгийн нийт (балансын) үнэ	Хөрөнгө хүлээн авах байгууллагын нэр
1	Дорнод аймгийн Прокурорын газар	Конторын барилгын 4 дүгээр давхар (309.5 м.кв)	107,031,380.00	Дорнод аймгийн Цагдаагийн газар
2	Тагнуулын ерөнхий газар	Хуучин барилга	289,566,916.43	Дорнод аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын газар
3	Сүхбаатар аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар	Авто граж, газар эзэмших эрх	1,017,000.00	Сүхбаатар аймгийн Орон нутгийн өмчийн газарт
4	Сүхбаатар аймгийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар	Халуун усны барилга	80,000,000.00	Сүхбаатар аймгийн Орон нутгийн өмчийн газарт
5	Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Барилга, байгууламж, газар эзэмших эрх	32,504,370.00	
6	Увс аймгийн Ургамал газар тариалан, эрдэм шинжилгээний хүрээлэн	Барилга, байгууламж, газар эзэмших эрх	61,833,912.00	Увс аймгийн Баруун туруун сумын ЗДТГ
7	Ховд аймгийн Татварын хэлтэс	Барилга, байгууламж, газар эзэмших эрх	154,011,700.00	Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газарт
8	Гаалийн ерөнхий газар	Горхи мэлхий хад амаралтын газар	1,107,137,600.00	НД-н 6-р хороо Тэрэлж байгалийн цонцолборт газар

9	Төр засгийн үйлчилгээг эрхлэх газар	Горхи амаралтын газар	187,909,826.70	НД-н 6-р хороо Тэрэлж байгалийн цонцолборт газар
10	Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газар	Автомашинны граж	30,576,000.00	Говь-Алтай аймаг Есөнбулаг сум
11	Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газар	Автомашинны граж	2,520,000.00	Баяншанд баг ОБГ-ын хуучин байр
12	Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газар	Автомашинны граж	750,000.00	Говь-Алтай аймаг Есөнбулаг сум
13	Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газар	Автомашинны граж	750,000.00	Баяншанд баг ОБГ-ын хуучин байр
14	Говь-Алтай аймгийн АШУИС-ийн салбар сургууль	Ариун цэврийн байр	46,046,725.59	Говь-Алтай аймаг Есөнбулаг сум
15	Говь-Алтай аймгийн АШУИС-ийн салбар сургууль	Граж 1	1,056,159.00	Говь-Алтай Есөнбулаг сум
16	Говь-Алтай аймгийн АШУИС-ийн салбар сургууль	Граж 2	379,134.00	Говь-Алтай Есөнбулаг сум
17	Говь-Алтай аймгийн АШУИС-ийн салбар сургууль	Граж 3	398,090.70	Говь-Алтай Есөнбулаг сум
18	Говь-Алтай аймгийн АШУИС-ийн салбар сургууль	Склад 1	731,187.00	Говь-Алтай Есөнбулаг сум
19	Говь-Алтай аймаг дахь Нисэх буудал ТӨҮГ	Уурын зуух барилгын хамт	9,159,316.82	Говь-Алтай / Есөнбулаг / 3-р баг, Жаргалант
20	Говь-Алтай аймаг дахь Нисэх буудал ТӨҮГ	Нүүрсний агуулах	1,440,918.75	Говь-Алтай / Есөнбулаг / 3-р баг, Жаргалант
21	Говь-Алтай аймаг дахь Нисэх буудал ТӨҮГ	И шингэний тоосгон байр	195,075.00	Говь-Алтай / Есөнбулаг / 3-р баг, Жаргалант
22	Говь-Алтай аймаг дахь Нисэх буудал ТӨҮГ	Зорчигчийн заал	34,630,417.39	Говь-Алтай / Есөнбулаг / 3-р баг, Жаргалант

23	"Алтай Улиастай" ЭХС ТӨХК	Бигэр сумын моторын барилга	2,264,343.47	ГАА Бигэр
24	"Алтай Улиастай" ЭХС ТӨХК	Шарга сум худгийн байр	554,037.30	Говь-Алтай аймаг, Шарга сум
25	"Алтай Улиастай" ЭХС ТӨХК	Баян-Уул сумын дизель станцын барилга	3,268,000.00	Говь-Алтай аймаг, Баян-Уул сум
26	Завхан аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс	Стандартын хуучин байр	46,235,720.00	Завхан аймаг улиастай сум Жинст баг Төвийн хэсэг Явуугийн гудамж 1-106
27	Завхан аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	Улсын бүртгэлийн хуучин байр	97,787,300.00	Завхан, Улиастай, 1-р баг, Жинст, Бэгзийн Явуухулангийн гудамж